



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/437

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох, эрх сэргээх,
хүчингүй болгох, түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.4, 10.1.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.20, 19.21, 19.22, 19.23 дахь хэсэг, Эрүүл мэндийн яамны "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын 2019 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, эрх сэргээх байгууллагын нэрсийг хоёрдугаар, хүчингүй болгох байгууллагын нэрсийг гуравдугаар, түдгэлзүүлэх байгууллагын нэрсийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081698


Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09
дүгээр сарын 25-ны өдрийн А/437
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох
байгууллагын нэр, чиглэл, хугацаа

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
Шинээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
1	Локи интернэйшнл ХХК	Эмнэлгийн тоног төхөөрөмж импортлох, ханган нийлүүлэх	3 жил
2	Дөмөн ХХК	Эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
Нэмэлтээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
1	Дэлгэр хэлт кэйр ХХК	Протез импортлох, ханган нийлүүлэх	3 жил
2	Гялс био ХХК	Оношлуур, урвалж импортлох ханган нийлүүлэх	3 жил

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09
дүгээр сарын 25-ны өдрийн А/1437
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийн эрх сэргээх байгууллагуудын нэр, чиглэл

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1.	Дөрвөн цацраг ХХК	Шүдний тусламж үйлчилгээ
2.	Номин төгөлдөр ХХК	Шүдний эмнэлгийн тусламж үйлчилгээ
3.	Сайн сайхан ХХК	Мэс засал, эмэгтэйчүүд, гоо сайханы мэс заслын тусламж үйлчилгээ /20-ортой/
4.	Жэй Пи Эн Эм ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09
дүгээр сарын 25-ны өдрийн А/1437
дугаар тушаалын гуравдугаар хавсралт



Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг хүчингүй болгох байгууллагын нэр, чиглэл

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1.	Монмиллион бат ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, импортлох

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09
дүгээр сарын 25-ны өдрийн А/437
дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг
түдгэлзүүлэх байгууллагын нэр, чиглэл, хугацаа

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1.	Арцны жимс ХХК	Эм үйлдвэрлэх /шахмал, үрэл, галены бэлдмэл/	3 сар